



МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН  
САЙДЫН ТУШААЛ

2020 оны 07 сарын 31 өдөр

Дугаар А/1413

Улаанбаатар хот

Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн дүрэм,  
бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 9 дүгээр зүйлийн 9.2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Зам, тээврийн хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн дүрмийг нэгдүгээр хавсралтаар, зөвлөлийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар, дэд зөвлөлийн бүрэлдэхүүнийг гуравдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 оны "Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн дүрэмд өөрчлөлт оруулах, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай" 37 дугаар тушаал, 2018 оны "Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай" 254 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Л.ХАЛТАР

Зам, тээврийн хөгжлийн сайдын  
2020 оны 07 сарын 31-ны өдрийн  
А/143 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ**  
**ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ**

**Нэг. Ерөнхий зүйл**

1.1. Энэхүү дүрмийн зорилго нь Зам, тээврийн хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөл( цаашид “Зөвлөл” гэх)-ийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**Хоёр. Зөвлөлийн бүрэлдэхүүн**

2.1. Зөвлөл нь дарга, дэд дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ.

2.2. Зөвлөлийн бүрэлдэхүүний (2/3) гуравны хоёроос доошгүй хувь нь докторын зэрэг эсхүл зөвлөх инженер байна.

2.3. Зөвлөл нь зам, тээврийн салбар тус бүрээр дэд зөвлөл(цаашид “Дэд зөвлөл” гэх)-тэй байна.

2.3.1. авто замын салбарын дэд зөвлөлийн чиг үүргийг “Авто замын салбарын Шинжлэх ухаан, техникийн зөвлөл” хариуцуулан ажиллуулах.

**Гурав. Зөвлөлийн бүрэн эрх**

3.1. Зөвлөл нь Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаатай холбогдсон бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

3.2. Зөвлөл нь энэхүү дүрмийн 3.1-т зааснаас гадна дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

3.2.1. зам, тээврийн салбарт шаардлагатай судалгаа, шинжилгээ, туршилтийн ажлын жагсаалтыг хэлэлцэх;

3.2.2. зам, тээврийн салбарын хэмжээнд нийтлэг мөрдөх техник, технологийн холбогдолтой дүрэм, журмын төсөл болон норм, норматив, техникийн баримт бичгийн төсөл, төсвийн жишиг үнэлгээ, техникийн дүгнэлт, инженерийн тооцоо судалгаа, шийдэл зэргийг хэлэлцэх;

3.2.3. зам, тээврийн салбарт хэрэгжүүлж байгаа эрдэм шинжилгээ, судалгааны төсөл түүний үр дүнг үйлдвэрлэлд хэрхэн нэвтрүүлж, ашиглаж байгаа тухай захиалагч болон гүйцэтгэгч байгууллагын тайланг хэлэлцэх;

3.2.4. гадаад, дотоодын хөрөнгөөр хэрэгжих төслүүдийн техник-эдийн засгийн үзүүлэлтийн урьдчилсан судалгааны тайлан, инженерийн хайгуул, зураг төслийн техникийн шийдэл, хувилбаруудын харьцуулалт зэрэг асуудлуудыг хэлэлцэх;

3.2.5. шинжлэх ухаан технологийн сан болон авто замын норм, нормативын сангийн хөрөнгөөр боловсруулсан норм норматив, техникийн баримт бичиг, судалгааны ажлын тайланг хэлэлцэх;

3.2.6. бусад асуудал.

#### Дөрөв. Зөвлөлийн үйл ажиллагаа

4.1. Зөвлөлийн үйл ажиллагааны хэлбэр нь хурал байх бөгөөд түүнийг дарга удирдан явуулна.

4.2. Зөвлөлийн даргын эзгүйд түүний эрх олгосон дагуу дэд дарга хурлыг удирдах бөгөөд ажлын үр дүнг биечлэн хариуцна.

4.3. Зөвлөлийн хуралд бүх гишүүдийн (2/3) гуравны хоёроос дээш хувь нь оролцсон тохиолдолд хүчинтэйд тооцно.

4.4. Зөвлөлийн хурлын тэмдэглэл, шийдвэрт зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж баталгаажсан байна.

4.5. Зөвлөлийн гишүүн хүндэтгэх шалтгаанаар хуралд оролцож чадахгүй тохиолдолд даргад мэдэгдэж чөлөө авна.

4.6. Чөлөө авсан гишүүн хэлэлцэх асуудалтай холбогдуулан нарийн бичгийн даргад саналаа бичгээр болон цахим хэлбэрээр өгч болох бөгөөд түүнийг санал хураалтад оруулж тооцно.

4.7. Хурлыг шаардлагатай тохиолдолд цахим хэлбэрээр зохион байгуулж болно.

#### Тав. Зөвлөлийн хурлын бэлтгэл ажлыг хангах

5.1. Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх асуудлын материал, бусад холбогдох бичиг баримтын эх хувийг нарийн бичгийн даргад цаасаар болон цахим хэлбэрээр ирүүлсэн байна.

5.2. Нарийн бичгийн дарга нь хурлаар хэлэлцүүлэх материал, холбогдох газар, байгууллагуудаас ирүүлсэн санал, Дэд зөвлөлийн санал, зөвлөмжийг Зөвлөлийн даргад танилцуулах ба түүний зөвшөөрлийг үндэслэн хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд оруулж, гишүүдэд ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө цахим хэлбэрээр хүргүүлнэ.


5.3. Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх материал нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

5.3.1. Танилцуулга бэлтгэж, тухайн асуудлыг хэлэлцүүлэх болсон үндэслэл, шаардлага, эдийн засгийн тооцоо, үүсч болох нийгэм эдийн засгийн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, ач холбогдол, үр дүнг тодорхойлсон байх;

5.3.2. Хуралд хэлэлцүүлэх асуудлыг тухайн чиглэлийн холбогдох байгууллага, их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, зураг төслийн зөвлөх болон гүйцэтгэгч байгууллага, эрдэмтэд, зөвлөх инженерийн санал, шүүмжийг бичгээр гаргуулан авч хавсарган саналыг хэрхэн тусгасан талаар товъёог хийсэн байх;

5.3.3. Хуралд оруулж буй асуудал нь урьдчилан тус яамны холбогдох газар, шаардлагатай бол харьяа газар, байгууллагуудын санал авсаны үндсэн дээр хэлэлцэгдсэн байх;

5.3.4. Хуралд оруулж буй асуудал нь урьдчилан Дэд зөвлөлийн хурлаар хэлэлцэгдсэн санал, зөвлөмж гаргасан байх;



5.3.5. Зөвлөлийн хурлаас гарах шийдвэрийн төсөл боловсруулан хавсаргасан байх.

5.4. Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх асуудлаар зайлшгүй шаардлагатай гэж үзвэл мэргэжлийн экспертизийн дүгнэлт гаргуулахаар ажлын хэсэг, эсхүл шинжээч томилж болно.

5.5. Зөвлөлийн дарга нь яаралтай хэлэлцэх асуудлаар хурлыг шууд зарлан зохион байгуулж болох бөгөөд уг хэлэлцэх асуудал энэхүү журмын 5.3 дахь заалтыг хангасан байна.

### Зургаа. Зөвлөлийн хурал

6.1. Зөвлөлийн дарга хурлыг нээж, нарийн бичгийн дарга хэлэлцэх асуудлыг танилцуулна.

6.2. Хэлэлцэж буй асуудлыг оруулж байгаа газар, байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөлөл товч танилцуулга хийсний дараа Зөвлөлийн гишүүд уг асуудлаар асуулт тавьж, хариулт авна.

6.3. Хэлэлцэх асуудалд өгсөн тухай Дэд зөвлөлийн санал, зөвлөмж, холбогдох газар, байгууллагуудаас ирүүлсэн саналыг тус тус танилцуулна.

6.4. Хэлэлцүүлэг дууссаны дараа Зөвлөлийн гишүүд санал гаргана.

6.5. Зөвлөлийн дарга, дэд дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийн олонхын саналаар хурлын шийдвэр гаргах бөгөөд уг шийдвэр нь зөвлөмжийн хэлбэртэй байна.

6.6. Хурлаар хэлэлцүүлэх асуудлын онцлогийг харгалзан Зөвлөлийн даргын зөвшөөрснөөр мэргэжлийн байгууллага, холбогдох албан тушаалтныг хуралд оролцуулж болно.

6.7. Зөвлөлийн хурлын явцыг баримтжуулах зорилгоор тэмдэглэл хөтлөх ба түүнд хуралд оролцсон бүх гишүүд, тухайн асуудал бүр дээр тэдгээрийн гаргасан санал, зөвлөмж, санал хураалтын дүнг заавал тусгаж, баталгаажуулна.

6.8. Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь хурлаас гарсан шийдвэрийг холбогдох байгууллага, газарт хүргүүлэх, биелэлтийг тогтоосон хугацаанд тайлагнах, хэлэлцсэн материалын баримт бичгийг нэгтгэн зохих журмын дагуу архивын нэгж бүрдүүлэн зохих журмын дагуу шилжүүлэх үүргийг хүлээнэ.

### Долоо. Зөвлөлийн үйл ажиллагааны санхүүжилт


7.1. Зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудал оруулж байгаа газар, байгууллага, аж ахуйн нэгж нь гишүүдийн цагийн хөлсийг хариуцна.

7.2. Зөвлөлийн үйл ажиллагааны зардал нь хуралд оролцсон гишүүдийн урамшуулал, бичиг хэргийн зардлаас бүрдэх бөгөөд уг зардлыг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 142 дугаар тушаалаар батлагдсан "Авто замын норм, норматив сангийн ажиллах журам"-ын 4.1.6-д заасны дагуу зарцуулна.

7.3. Зөвлөлийн дарга, дэд дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийн нэг цагийн хорин таван мянган (25000) төгрөг, Дэд зөвлөлийн ахлагч, нарийн бичиг, гишүүдийн нэг цагийн хорин мянган (20000) төгрөгийн хөлс, урамшууллыг тус тус олгоно.

7.4. Урамшууллыг гишүүдийн оролцоо, ажлын үр дүнг харгалзан олгож болно:

7.4.1. Хуралд асуулт асууж оролцсон байдал ба идэвх;



7.4.2. Хэлэлцсэн асуудлаар шийдвэрт эерэгээр нөлөөлөхүйц үндэслэл гаргасан байдал.

Найм. Зөвлөлийн гишүүний ёс зүйн хэм хэмжээ

8.1. Гишүүн нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 3 буюу түүнээс дээш дараалан хуралд оролцоогүй нь зөвлөлийн бүрэлдэхүүнээс чөлөөлөх үндэслэл болно.


8.2. Гишүүд аливаа санал гаргахдаа улсын төсвийг хэмнэлттэй зарцуулах, хэрэглэгчид ба нийтийн эрх ашигт нийцсэн шийдвэр гаргах, инженерийн ёс зүйтэй байхыг тус тус шаардана.

8.3. Гишүүн нь ашиг сонирхлын зөрчил үүсч болзошгүй тохиолдолд түүнийгээ Зөвлөлийн даргад бичгээр мэдэгдэж, санал хураалтад оролцохоос татгалзах үүрэгтэй бөгөөд энэ нь мэргэжлийн зүгээс хэлэлцүүлэгт оролцохыг хязгаарлах үндэслэл болохгүй.

-----oOo-----



Зам, тээврийн хөгжлийн сайдын  
 2020 оны 07 сарын 31-ны өдрийн  
 А/ЧБ дугаар тушаалын хоёрдугаар хавсралт




ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ  
 ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН


№	Овог, нэр	Байгууллага, албан тушаал	Мэргэжил, эрдмийн цол, зэрэг
<b>Дарга</b>			
1	Ж.Бат-Эрдэнэ	Дэд сайд, Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөлийн гишүүн	Системийн инженер, Зөвлөх инженер
		Дэд дарга	
2	Д.Гэрэлням	Бодлого, төлөвлөлтийн газрын дарга	Авто замын инженер, Доктор /Ph.D/, Зөвлөх инженер
<b>Нарийн бичгийн дарга</b>			
3	Ө.Одгэрэл	Бодлого, төлөвлөлтийн газрын Стандарт, нормативын хэлтсийн шинжээч	Электроникийн инженер, Доктор /Ph.D/, Зөвлөх инженер, Дэд профессор
<b>Гишүүд</b>			
4	М.Энхболд	Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга	Төмөр замын инженер, Зөвлөх инженер
5	Ц.Баяржаргал	Авто тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын шинжээч	Авто тээврийн инженер, Доктор /Ph.D/
6	Б.Алтанцом	Иргэний нисэхийн ерөнхий газрын дэд дарга	Нислэгийн хөдөлгөөний инженер, Магистр
7	Г.Ундраа	Иргэний нисэхийн ерөнхий газрын мэдээлэл, инноваци, судалгаа хариуцсан мэргэжилтэн	Бизнесийн удирдлага, Агаарын тээврийн удирдлагын магистр
8	А.Мөнхболд	Үндэсний хөгжлийн газрын Судалгааны албаны дарга	Инженер эдийн засаг, Доктор /Ph.D/, (зөвшилцсөнөөр)
9	Л.Болд	"Улаанбаатар төмөр зам" ХНН-ийн Вагоны албаны дарга	Вагоны инженер, Доктор /Ph.D/ (зөвшилцсөнөөр)

10	Ё.Батсайхан	“Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн Их барилга, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах инженер	Төмөр замын инженер, Зөвлөх инженер, (зөвшилцсөнөөр)
11	Б.Болд	ШУТИС-ийн Барилга архитектурын сургуулийн Хүрээлэн байгаа орчны инженерийн салбарын эрхлэгч	Авто замын инженер, Доктор /Ph.D/, Зөвлөх инженер, (зөвшилцсөнөөр)
12	Б.Эрдэнэбат	ШУТИС-ийн Механик тээврийн сургуулийн профессор	Цэргийн нисэхийн инженер, Доктор /Ph.D/, (зөвшилцсөнөөр)
13	И.Базаррагчаа	ШУТИС-ийн Механик тээврийн сургуулийн тэнхимийн эрхлэгч	Автотээврийн инженер, Доктор/Ph.D/, Дэд профессор (зөвшилцсөнөөр)
14	Х.Гантөмөр	Төслийн зөвлөх инженер	Гүүрийн барилгын инженер, Зөвлөх инженер, (зөвшилцсөнөөр)
15	Д.Готов	“Монголын авто инженерүүдийн нийгэмлэг” ТББ-ын тэргүүн	Автотээврийн инженер, Доктор /Sc.D/ (зөвшилцсөнөөр)
16	Ц.Цэвэгжав	ШУТИС-ийн Механик тээврийн сургуулийн профессор	Автотээврийн инженер, Доктор /Ph.D/ (зөвшилцсөнөөр)
17	Т.Бямбаа	“Монголын авто замчдын холбоо” ТББ-ын ерөнхийлөгч	Авто замын инженер, Зөвлөх инженер, (зөвшилцсөнөөр)
18	Ж.Батсайхан	“Эм Си Пи Си жи ар” ХХК-ийн захирал	Авто замын инженер, Доктор /Ph.D/, Зөвлөх инженер, (зөвшилцсөнөөр)
19	Н.Батнасан	МУИС-ийн Бизнесийн сургуулийн профессор	Гадаад худалдааны эдийн засаг, Доктор /Ph.D/, Дэд профессор

---оОо---



Зам, тээврийн хөгжлийн сайдын  
2020 оны 07 сарын 01-ны өдрийн  
А/143. дугаар тушаалын гуравдугаар хавсралт



АВТОТЭЭВРИЙН САЛБАРЫН ДЭД ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Ахлагч: Ё.Жаргалсайхан  
Автомобильн замын зөвлөлийн бүрэлдэхүүнийг зохицуулах газрын дарга, доктор (Ph.D)
- Нарийн бичиг: Ц.Баяржаргал  
Автомобильн замын зөвлөлийн бүрэлдэхүүнийг зохицуулах газрын шинжээч, доктор (Ph.D)
- Гишүүд: Ц.Нэргүйбаатар  
Автомобильн замын зөвлөлийн бүрэлдэхүүнийг зохицуулах газрын ахлах шинжээч
- Ө.Одгэрэл  
Бодлого, төлөвлөлтийн газрын Стандарт, нормативын хэлтсийн шинжээч, доктор(Ph.D)
- Х.Булгаа  
Нийслэлийн тээврийн үйлчилгээний газрын орлогч дарга, доктор (Ph.D) (зөвшилцсөнөөр)
- А.Батчулуун  
“АТҮТ” ТӨҮГ-ын Судалгаа, хөгжил чанарын удирдлагын төвийн ахлах мэргэжилтэн (зөвшилцсөнөөр)
- А.Цэцэгмаа  
“Төмөрлөг машин үйлдвэрлэл, инженерингийн ассоциаци”-ийн тэргүүн, доктор (Ph.D) (зөвшилцсөнөөр)
- Гишүүн  
Аж ахуйн нэгжийн төлөөлөл (тухай бүр зөвшилцсөнөөр)
- Гишүүн  
Төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөлөл (тухай бүр зөвшилцсөнөөр)
- Гишүүн  
Их, дээд сургуулийн төлөөлөл (тухай бүр зөвшилцсөнөөр)


Тайлбар: Тухайн хэлэлцэх асуудлаас хамаарч дэд зөвлөлийн бүрэлдэхүүнийг өргөтгөж болно.



ТӨМӨР ЗАМ, ДАЛАЙН ТЭЭВРИЙН САЛБАРЫН  
ДЭД ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ахлагч:	Б.Артур	Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
Нарийн бичиг:	Т.Мөнхцэцэг	Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын шинжээч доктор(Ph.D)
Гишүүд:	А.Буяннэмэх	“Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” УТҮГ-ын дарга
	Д.Түвшинбаяр	Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн Зүтгүүрийн аж ахуйн албаны орлогч дарга (зөвшилцсөнөөр)
	Ж.Болд	Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн Замын аж ахуйн албаны Үйлдвэрлэл техникийн хэлтсийн дарга (зөвшилцсөнөөр)
	М.Бямбасүрэн	Төмөр замын дээд сургуулийн Механикийн багш, Эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор (Ph.D) (зөвшилцсөнөөр)
	Б.Хүдэрхүү	“Монголын төмөр зам” ТӨХК-ийн Тээвэр зохион байгуулалтын инженер (зөвшилцсөнөөр)
	Гишүүн	Аж ахуйн нэгжийн төлөөлөл (тухай бүр зөвшилцсөнөөр)
	Гишүүн	Төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөлөл (тухай бүр зөвшилцсөнөөр)
	Гишүүн	Их, дээд сургуулийн төлөөлөл (тухай бүр зөвшилцсөнөөр)

Тайлбар: Тухайн хэлэлцэх асуудлаас хамаарч дэд зөвлөлийн бүрэлдэхүүнийг өргөтгөж болно.



## ИРГЭНИЙ НИСЭХИЙН САЛБАРЫН ДЭД ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ахлагч:

Ч.Мөнхтуяа

Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга

Нарийн бичиг:

Ө.Мөнгөнжигүүр

Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн

Гишүүд:

Б.Болор-Эрдэнэ

Иргэний нисэхийн ерөнхий газрын Агаарын тээврийн бодлого зохицуулалтын газрын Эдийн засгийн зохицуулалтын тасгийн ахлах мэргэжилтэн

П.Ганболд

Иргэний нисэхийн ерөнхий газрын Агаарын навигац, нисэх буудлын бодлого, зохицуулалтын газрын Төсөл, хөтөлбөрийн хэлтсийн дарга

Б.Нямбаяр

Иргэний нисэхийн үндэсний төвийн Мэдээллийн технологи инновацийн албаны дарга (зөвшилцсөнөөр)

Л.Нямбаяр

Монголын агаарын тээвэрлэгчдийн холбооны ерөнхийлөгч (зөвшилцсөнөөр)

А.Баасандагва

Монголын нисэх буудлуудын холбооны менежер (зөвшилцсөнөөр)

Гишүүн

Аж ахуйн нэгжийн төлөөлөл (тухай бүр зөвшилцсөнөөр)

Гишүүн

Төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөлөл (тухай бүр зөвшилцсөнөөр)

Гишүүн

Их, дээд сургуулийн төлөөлөл (тухай бүр зөвшилцсөнөөр)

Тайлбар: Тухайн хэлэлцэх асуудлаас хамаарч дэд зөвлөлийн бүрэлдэхүүнийг өргөтгөж болно.

